



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/104

Пионер толгой

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
Засаг даргын Тамгын газрын халаалтын ажлыг
хүлээн авах, барилгын талбайн хэмжээг тогтоох
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн үйл ажиллагааны журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/02 тоот тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрыг нэгдсэн халаалтад холбох сантехникийн ажлыг хүлээн авах, барилгын талбайн хэмжээг тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	С.Далайжаргал	Хөвийн илч ХХК-ны сантехникийн инженер
	Д.Мөнхчулуун	Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга
	М.Болормаа	ИТХ-ын Архив бичиг хэргийн эрхлэгч
	П.Цэцэгдэмбэрэл	Нярав
	Л.Энэбиш	Жолооч
	А.Баяртогтох	Үйлчлэгч

2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын газрыг нэгдсэн халаалтад холбох сантехникийн ажлыг хүлээн авах, ажлыг техникийн тодорхойлолтын дагуу акт үйлдэн хүлээн авах, барилгын талбайн хэмжээг тогтоож баталгаажуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ОРЛОГЧ ДАРГА



Э.СҮГЛЭГМАА

2023/Засаг дарга/Захирамж2023

642201459